



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биокомбинат ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/013/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: baterdenes@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



БИОКОМБИНАТ ТӨХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
М.ЭНХ-АМАР ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1093  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Биокомбинат ТӨХХК нь тайлант онд Мал эмнэлгийн ерөнхий газар болон аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газруудын захиалгаар 10,328.7 сая төгрөгийн өртөг бүхий 19 нэр, төрлийн вакцин, 22 нэр, төрлийн оношлуур, 3 нэр төрлийн шингэлэгч уусмал, нийт 47 нэр, төрлийн 26.3 сая тун хатаасан бэлдмэл, 126,888.0 литр шингэн биобэлдмэлийг тус тус үйлдвэрлэн борлуулжээ.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Биокомбинат ТӨХХК нь Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөлөлттэй зээлээр Шингэн вакцины савлагааг автоматжуулах төсөл, Дэлхийн банкны “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн санхүүжилтээр “Шугаман эсийн технологи нэвтрүүлэх”

төслийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Төслүүд хэрэгжиж орчин үеийн автомат ажиллагаатай тоног төхөөрөмжийг суурилуулснаар үйлдвэрлэлийн хүчин чадал 50-60 хувиар нэмэгдэх, вакцины дотоод хэрэгцээг бүрэн хангах, вакцин биобэлдмэлийн тоо хэмжээ, чанар, хүртээмж дээшилж, малын гоц халдварт өвчний тархалт буурах, мал сүрэг эрүүлжиж хүнсний аюулгүй байдал хангагдах зэрэг урьдчилсан тооцоотой байна.

### **Бусад асуудал**

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	234,644,143.14	2,001,548,149.29
1.1.02	Дансны авлага	165,502,119.46	2,604,163,949.14
1.1.04	Бусад авлага	-	3,847,886.71
1.1.06	Бараа материал	5,825,769,812.40	7,233,665,981.28
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,225,916,075.00</b>	<b>11,843,225,966.42</b>
1.2.01	Үндсэн хөрөнгө	6,499,047,311.64	5,688,161,690.58
1.2.02	Биет бус хөрөнгө	4,630,969,480.00	4,622,221,480.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>11,130,016,791.64</b>	<b>10,310,383,170.58</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,355,932,866.64</b>	<b>22,153,609,137.00</b>
2.1.1.01	Дансны өглөг	369,740,182.07	22,849,250.00
2.1.1.03	Татварын өр	1,609,907.34	42,150,404.13
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	0.08
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	-	1,882,587,207.90
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>371,350,089.41</b>	<b>1,947,586,862.11</b>
2.1.2.01	Урт хугацаат зээл	630,000,000.00	3,490,000,000.00
<b>2.1.2.06</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>630,000,000.00</b>	<b>3,490,000,000.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,001,350,089.41</b>	<b>5,437,586,862.11</b>
2.3.01	Өмч: - төрийн	2,141,020,492.31	2,141,020,492.31
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,954,691,884.19	8,954,586,938.74
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	4,601,068,480.00	4,601,068,480.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	657,801,920.73	1,019,346,363.84
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	369,070,837.20
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	657,801,920.73	650,275,526.64
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>16,354,582,777.23</b>	<b>16,716,022,274.89</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>17,355,932,866.64</b>	<b>22,153,609,137.00</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	8,148,402,574.30	10,328,746,558.05
02	Борлуулалтын өртөг	6,822,765,571.12	8,166,034,267.84
<b>03</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>1,325,637,003.18</b>	<b>2,162,712,290.21</b>
04	Түрээсийн орлого	-	97,800,000.00
05	Хүүний орлого	23,155,008.61	5,225,774.57
08	Бусад орлого	208,616,156.54	82,693,025.84
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,525,714,199.39	1,777,671,791.27
11	Санхүүгийн зардал	40,430,465.75	120,379,186.27
12	Бусад зардал	-	1,391,418.13
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(205,333.44)
17	Бусад ашиг ( алдагдал)	40,020,606.27	(27,279,320.18)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>31,284,109.46</b>	<b>421,504,041.33</b>
19	Орлогын татварын зардал	1,609,907.34	42,150,404.13
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>29,674,202.12</b>	<b>379,353,637.20</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>29,674,202.12</b>	<b>379,353,637.20</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>01</b>	<b>2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>2,141,020,492.31</b>	<b>8,944,423,800.98</b>	<b>4,601,068,480.00</b>	<b>650,328,578.61</b>	<b>16,336,841,351.90</b>
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(13,092,230.00)	(13,092,230.00)
<b>03</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,141,020,492.31</b>	<b>8,944,423,800.98</b>	<b>4,601,068,480.00</b>	<b>637,236,348.61</b>	<b>16,323,749,121.90</b>
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	29,674,202.12	29,674,202.12
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	(9,108,630.00)	(9,108,630.00)
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	10,268,083.21	-	-	10,268,083.21
<b>09</b>	<b>2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>2,141,020,492.31</b>	<b>8,954,691,884.19</b>	<b>4,601,068,480.00</b>	<b>657,801,920.73</b>	<b>16,354,582,777.23</b>
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(7,526,394.09)	(7,526,394.09)
<b>11</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,141,020,492.31</b>	<b>8,954,691,884.19</b>	<b>4,601,068,480.00</b>	<b>650,275,526.64</b>	<b>16,347,056,383.14</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	379,353,637.20	379,353,637.20
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(10,282,800.00)	(10,282,800.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(104,945.45)	-	-	(104,945.45)
<b>17</b>	<b>2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл</b>	<b>2,141,020,492.31</b>	<b>8,954,586,938.74</b>	<b>4,601,068,480.00</b>	<b>1,019,346,363.84</b>	<b>16,716,022,274.89</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>8,721,920,030.14</b>	<b>12,287,501,291.35</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,933,004,262.62	12,080,653,024.79
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	853,829.00	2,823,325.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	788,061,938.52	204,024,941.56
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>8,136,036,720.17</b>	<b>11,414,633,405.20</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,108,842,004.03	3,055,625,288.49
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	302,957,977.66	496,295,585.55
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	449,712,154.00	2,683,852,076.90
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	133,123,892.28	266,800,655.32
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	259,715,850.00	649,417,460.84
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	41,685,090.51	123,332,501.34
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	94,605,313.30	380,064,570.48
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	114,750.00	315,316,867.73
1.2.9	Бусад мөнгөн зарлага	5,745,279,688.39	3,443,928,398.55
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>585,883,309.97</b>	<b>872,867,886.15</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>49,423,076.61</b>	<b>13,103,480.27</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	7,900,000.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	53,660.00	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	23,155,008.61	5,203,480.27
2.1.8	Бусад	26,214,408.00	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>918,433,259.00</b>	<b>2,582,147,300.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	918,433,259.00	2,537,147,300.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	45,000,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(869,010,182.39)</b>	<b>(2,569,043,819.73)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>608,394.54</b>	<b>3,490,000,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	3,490,000,000.00
3.1.4	Бусад	608,394.54	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>14,252,054.00</b>	<b>26,920,060.27</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	16,637,260.27
3.2.4	Төлсөн ногдол ашиг	9,108,630.00	10,282,800.00
3.2.5	Бусад	5,143,424.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(13,643,659.46)	3,463,079,939.73
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(296,770,531.88)</b>	<b>1,766,904,006.15</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>531,414,675.02</b>	<b>234,644,143.14</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>234,644,143.14</b>	<b>2,001,548,149.29</b>

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
1	1	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэл</b>					
	2	Шингэн бэлдмэл	литр	128,260.9	126,888.0	1,372.9	98.9
	3	Хатаасан бэлдмэл	мян.тун	25,791.8	26,273.9	(482.1)	101.9
2	1	<b>Нийт орлого</b>	<b>мян.төг</b>	<b>13,497,593.0</b>	<b>10,514,465.4</b>	<b>2,983,127.6</b>	<b>77.9</b>
	2	Үндсэн үйлдвэрлэлийн орлого	мян.төг	13,182,593.0	10,328,746.6	2,853,846.4	78.4
	3	Үйл ажиллагааны бусад орлого	мян.төг	315,000.0	185,718.8	129,281.2	59.0
3	1	<b>Нийт зардал</b>	<b>мян.төг</b>	<b>13,414,663.2</b>	<b>10,092,961.3</b>	<b>3,321,701.9</b>	<b>75.2</b>
	2	Үйл ажиллагааны зардал	мян.төг	13,287,474.6	9,945,841.4	3,341,633.2	74.9
	3	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	127,188.6	147,119.9	(19,931.3)	115.7
4	1	<b>Татварын өмнөх ашиг(алдагдал)</b>	<b>мян.төг</b>	<b>82,851.5</b>	<b>421,504.1</b>	<b>(338,652.6)</b>	<b>508.7</b>
5	1	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	74,566.4	379,353.6	(304,787.3)	508.7
6	1	Их засвар, хөрөнгө оруулалт ТЗБАХ	мян.төг	140,278.3	78,795.9	61,482.4	56.2
7	1	<b>Нийт өр төлбөр</b>	<b>мян.төг</b>	<b>5,031,000.0</b>	<b>5,437,586.9</b>	<b>(406,586.9)</b>	<b>108.1</b>
	2	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	31,000.0	1,947,586.9	(1,916,586.9)	6282.5
8	1	Нийт авлага	мян.төг	156,576.9	2,608,011.8	(2,451,434.9)	1665.6
9	1	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	мян.төг	1	1	-	103.5
10	1	Цалингийн сан	мян.төг	5,634,613.7	5,134,613.7	500,000.0	91.1
11	1	Ажиллагсдын тоо	хүн	234	234	-	100.0
	2	Нэг ажилтны дундаж цалин /жил/	мян.төг	24,079.5	21,942.79	2,136.8	91.1

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 79.2 сая төгрөгийн 3 зөрчил илэрснээс 16.5 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 62.7 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 1 ажилтанд ажилгүй байсан хугацааны цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 16.5 сая төгрөгийг байгууллагын данснаас шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр хасан авсныг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.	1	16,461.5	-	-	1	16,461.5	-	-	-	-	-	-
Тайлант онд худалдан авсан бараа ажил үйлчилгээний 62.7 сая төгрөгийн худалдан авалтын и баримт татварын цахим системд бүртгэгдээгүй байна.	1	62,723.9	-	-	-	-	1	62,723.9	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 4,248.6 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгааг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>79,185.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>16,461.5</b>	<b>2</b>	<b>62,723.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**3.2** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

Санхүүгийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 201.1 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	-	-	-	-	-	-	-	-
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Тайлант онд 201.1 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг 4 аж ахуйн нэгж, байгууллагаас шууд гэрээгээр гүйцэтгэсэн байна.	1	201,088.2	-	-	1	201,088.2	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>201,088.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>201,088.2</b>	<b>-</b>	<b>-</b>